

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/11/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Монгол Улсын ерөнхий аудиторовн Орлогч: Я.Самбууням Утас: 261945 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Аудитор: Г.Ганбилэг Утас: 261628 Цахим хаяг: ganbilegg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МОНГОЛ УЛСЫН САЙД,ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Н.УЧРАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан улсын хэмжээнд нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгуулж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг танилцуулж, саналыг нэгтгэж Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлагтай байгуулсан хэлэлцээр 2023 онд дуусгавар болсонтой холбоотой, Төвлөрлийн сааруулах бодлогын дэмжлэг төсөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцын чадавхыг бэхжүүлэх дэд төслүүд хаагдаж, 12 нэр төрлийн 55.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 587 дугаар тогтоолоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт балансаас балансад шилжүүлэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 39 зорилтын хүрээнд 210 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас нийт хэрэгжилт 91.9 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,707,144,302.18	147,298,080,666.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,657,815,282.07	25,709,481,518.13
33	АВЛАГА	1,120,763,007.45	436,435,430.51
34	УРЬДЧИЛГАА	3,150,469,290.22	8,955,255,224.77
35	БАРАА МАТЕРИАЛ	3,724,709,377.44	3,888,054,112.89
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	64,053,387,345.00	108,308,854,380.09
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	64,671,515,649.11	65,284,680,739.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	64,671,515,649.11	65,284,680,739.13
39200	Биет хөрөнгө	57,171,514,731.47	58,220,154,242.34
39300	Биет бус хөрөнгө	7,500,000,917.64	7,064,526,496.79
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	157,378,659,951.29	212,582,761,405.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,992,680,988.11	9,879,824,222.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,992,680,988.11	9,879,824,222.20
41300	Өглөг	3,222,707,586.11	8,404,028,931.29
41360	Бусад өглөг	3,222,707,586.11	8,404,028,931.29
41400	Урьдчилж орсон орлого	2,769,973,402.00	1,475,795,290.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	151,385,978,963.18	202,702,937,183.32
51	Засгийн газрын хувь оролцоо	151,385,978,963.18	202,702,937,183.32
51100	Засгийн газрын оруулсан капитал	37,885,011,456.04	39,540,081,736.04
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	37,885,011,456.04	39,540,081,736.04
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	757,597,449.00	757,597,449.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,537,847,455.91	1,776,603,155.91
51200	Хуримтлагдсан үр дүн	82,059,445,215.16	133,567,484,455.30
51210	Өмнөх үеийн үр дүн	52,089,288,653.19	82,126,303,606.46
51220	Тайлант үеийн үр дүн	29,970,156,561.97	51,441,180,848.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,146,077,387.07	27,061,170,387.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	157,378,659,951.29	212,582,761,405.52

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	111,718,543,500.25	164,575,305,512.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,326,152,858.35	29,443,881,355.09
120	Нийтлэг татварын бус орлого	41,986,192,858.35	29,412,284,794.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,030,594,206.47	21,027,711,586.37
121	Хөрөнгийн орлого	0.00	11,909,090.91
122	Тусламжийн орлого	1,339,960,000.00	19,687,470.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	68,392,390,641.90	135,131,424,157.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	61,096,804,123.00	118,368,588,856.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,295,586,518.90	16,762,835,301.28
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	80,645,902,946.95	111,937,253,743.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,643,408,277.95	111,783,196,288.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,600,434,133.82	100,197,937,904.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,787,274,198.87	33,097,960,753.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,263,997,028.03	3,938,160,836.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,106,404,960.02	3,316,551,865.55
2104	Хангамж, бараа материалын зардал	3,198,533,347.02	3,945,907,799.41
2105	Нормативт зардал	37,009,043.30	45,151,999.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,363,476,653.15	3,722,413,461.14
2107	Томилолт, зочны зардал	4,703,180,734.41	7,082,933,115.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,204,842,663.37	21,665,755,977.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,935,715,505.65	23,383,102,097.44
212	ТАТААС	363,906,856.00	412,684,936.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	363,906,856.00	412,684,936.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,679,067,288.13	11,172,573,447.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	51,286,092.55	51,283,301.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,718,876,533.76	1,889,788,811.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,908,904,661.82	9,231,501,334.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,494,669.00	154,057,455.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,494,669.00	154,057,455.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,072,640,553.30	52,638,051,768.61
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,900,487.70	1,392,248.43
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,106,384,479.03	1,198,263,168.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	29,970,156,561.97	51,441,180,848.84

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,909,971,543.6	122,909,971,543.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,568,908,642.4)	(1,568,908,642.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,341,062,901.2	121,341,062,901.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	74,759,500.0	74,759,500.0
5	Тайлант үеийн үр дүн	29,970,156,561.9	29,970,156,561.9
6	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,385,978,963.1	151,385,978,963.1
7	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	151,385,978,963.1	151,385,978,963.1
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,385,978,963.1	151,385,978,963.1
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(105,928,020.0)	(105,928,020.0)
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	10,000,000.0	10,000,000.0
11	Өмчид гарсан өөрчлөлт	(28,294,608.7)	(28,294,608.7)
12	Тайлант үеийн үр дүн	51,441,180,848.8	51,441,180,848.8
13	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	202,702,937,183.3	202,702,937,183.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	88,406,858,395.33	162,698,392,745.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,021,479,491.25	27,724,005,850.92
120	Нийтлэг татварын бус орлого	18,681,519,491.25	27,704,318,380.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,049,800,281.74	23,166,842,272.23
122	Тусламжийн орлого	1,339,960,000.00	19,687,470.00
122002	Хандив тусламж /гадаад/	1,339,960,000.00	19,687,470.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	68,385,378,904.08	134,974,386,894.28
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	61,096,804,123.00	118,368,588,856.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,288,574,781.08	16,605,798,038.28
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,200,388,999.62	113,688,597,840.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,200,388,999.62	113,688,597,840.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,144,361,731.25	102,056,513,941.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,263,740,094.82	32,427,438,936.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,630,855,360.39	4,333,784,492.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,237,381,994.54	3,543,757,663.28
2104	Хангамж, бараа материалын зардал	3,721,844,601.70	4,973,686,085.98
2105	Нормативт зардал	18,871,890.00	40,589,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,659,276,081.44	3,629,827,527.98
2107	Томилолт, зочны зардал	5,564,839,696.89	6,117,801,111.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,010,649,441.77	21,715,969,037.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,036,902,569.70	25,273,659,365.87
212	ТАТААС	354,130,975.00	412,684,936.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	354,130,975.00	412,684,936.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,701,896,293.37	11,219,398,963.17
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	51,286,092.55	51,283,301.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,741,705,539.00	1,936,614,326.87
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,908,904,661.82	9,231,501,334.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	11,206,469,395.71	49,009,794,904.84
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,547,278,673.66	44,137,802,577.05
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,547,278,673.66	44,137,802,577.05
2200	Дотоод эх үүсвэрээр	8,547,278,673.66	44,137,802,577.05
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,547,278,673.66)	(44,137,802,577.05)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(26,531,344.27)	(19,080,169.73)
14	Бусад эх үүсвэр	3,900,487.70	1,392,248.43
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	30,431,831.97	20,472,418.16
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,632,659,377.78	4,852,912,158.06
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,025,155,904.29	20,657,815,282.07
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,657,815,282.07	25,709,481,518.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,099,857,400.00	109,584,558,474.66	128,515,298,925.34	46.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,748,379,700.00	65,776,756,354.66	16,971,623,345.34	79.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,877,079,000.00	64,334,407,926.90	15,542,671,073.10	80.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,274,112,200.00	19,280,996,983.84	3,993,115,216.16	82.8
210101	Үндсэн цалин	13,409,314,900.00	11,807,986,382.50	1,601,328,517.50	88.1
210102	Нэмэгдэл	7,050,493,800.00	5,356,926,054.28	1,693,567,745.72	76.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,669,567,200.00	1,135,708,545.42	533,858,654.58	68.0
210104	Урамшуулал	1,144,736,300.00	980,376,001.64	164,360,298.36	85.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,916,989,200.00	2,371,234,070.30	545,755,129.70	81.3
210201	Тэтгэврийн даатгал	1,987,594,200.00	1,868,454,616.25	119,139,583.75	94.0
210202	Тэтгэмжийн даатгал	237,564,400.00	292,836,013.56	-55,271,613.56	123.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	117,933,500.00	39,688,180.31	78,245,319.69	33.7
210204	Ажилгүйдлийн даатгал	114,779,600.00	34,474,173.99	80,305,426.01	30.0
210205	Эрүүл мэндийн даатгал	459,117,500.00	135,781,086.19	323,336,413.81	29.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,000,927,200.00	1,407,220,012.27	593,707,187.73	70.3
210301	Гэрэл, цахилгаан	790,082,500.00	588,236,393.33	201,846,106.67	74.5
210302	Түлш, халаалт	571,972,100.00	413,506,914.41	158,465,185.59	72.3
210303	Цэвэр, бохир ус	392,872,600.00	170,921,468.53	221,951,131.47	43.5
210304	Байрны түрээс	246,000,000.00	234,555,236.00	11,444,764.00	95.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,138,772,400.00	937,341,047.46	201,431,352.54	82.3
210401	Бичиг хэрэг	200,355,300.00	168,809,773.01	31,545,526.99	84.3
210402	Тээвэр, шатахуун	422,109,600.00	403,423,524.00	18,686,076.00	95.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	199,469,700.00	125,890,547.58	73,579,152.42	63.1
210404	Ном, хэвлэл	6,407,200.00	5,254,313.00	1,152,887.00	82.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,248,700.00	1,248,700.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	309,181,900.00	232,714,189.87	76,467,710.13	75.3
2105	Нормативт зардал	27,577,700.00	26,620,470.00	957,230.00	96.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,577,700.00	16,620,470.00	957,230.00	94.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,217,580,300.00	2,123,982,702.20	93,597,597.80	95.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,066,788,400.00	1,012,207,346.60	54,581,053.40	94.9
210602	Тавилга	551,182,000.00	536,531,510.00	14,650,490.00	97.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,017,000.00	28,687,000.00	330,000.00	98.9
210604	Урсгал засвар	570,592,900.00	546,556,845.60	24,036,054.40	95.8
2107	Томилолт, зочны зардал	7,129,132,700.00	5,935,714,515.11	1,193,418,184.89	83.3
210701	Гадаад албан томилолт	2,035,403,900.00	2,041,497,846.15	(6,093,946.15)	100.3

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,773,414,700.00	1,627,924,792.50	1,145,489,907.50	58.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,320,314,100.00	2,266,291,876.46	54,022,223.54	97.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,566,556,800.00	21,737,873,606.74	6,828,683,193.26	76.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,170,204,300.00	21,469,076,628.70	6,701,127,671.30	76.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,470,000.00	0.00	4,470,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,050,000.00	0.00	1,050,000.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	0.00	100,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	361,168,000.00	239,233,287.04	121,934,712.96	66.2
210807	Газрын төлбөр	26,564,500.00	26,563,691.00	809.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,605,430,500.00	10,513,424,518.98	2,092,005,981.02	83.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,393,430,500.00	8,454,946,452.98	1,938,484,047.02	81.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,212,000,000.00	2,058,478,066.00	153,521,934.00	93.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,871,300,700.00	1,442,348,427.76	1,428,952,272.24	50.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	51,286,300.00	51,283,301.76	2,998.24	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	51,286,300.00	51,283,301.76	2,998.24	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,820,014,400.00	1,391,065,126.00	1,428,949,274.00	49.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,359,276,300.00	718,243,300.00	641,033,000.00	52.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	960,738,100.00	196,821,826.00	763,916,274.00	20.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000,000.00	476,000,000.00	24,000,000.00	95.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	155,351,477,700.00	43,807,802,120.00	111,543,675,580.00	28.2
220001	Барилга байгууламж	134,739,977,700.00	24,478,945,383.00	110,261,032,317.00	18.2
221001	Их засвар	6,714,700,000.00	5,891,417,512.00	823,282,488.00	87.7
222001	Тоног төхөөрөмж	13,896,800,000.00	13,437,439,225.00	459,360,775.00	96.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	238,099,857,400.00	109,429,227,899.42	128,670,629,500.58	46.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	237,924,857,400.00	109,156,142,414.42	128,768,714,985.58	45.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	237,924,857,400.00	109,156,142,414.42	128,768,714,985.58	45.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	175,000,000.00	273,085,485.00	(98,085,485.00)	156.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	530,000.00	-530,000.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000,000.00	272,555,485.00	(97,555,485.00)	155.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	220,938,593.25	(220,938,593.25)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	65,608,018.01	(65,608,018.01)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	10.00	10.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	10.00	10.00	0.00	100.0

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	564.00	564.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	35.00	35.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	354.00	354.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	175.00	175.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	564.00	564.00	0.00	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	274.00	274.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	224.00	224.00	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	10.00	10.00	0.00	100.0
650013	УТҮГ	56.00	56.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		16,955,723,103.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ		16,554,787,953.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		14,739,357,269.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		518,335,145.84
210101	Үндсэн цалин		260,568,940.45
210102	Нэмэгдэл		238,829,805.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт		18,936,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		37,788,724.16
210201	Тэтгэврийн даатгал		37,788,724.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		96,238,000.00
210304	Байрны түрээс		96,238,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		997,219,731.50
210401	Бичиг хэрэг		21,692,000.00
210402	Тээвэр, шатахуун		64,916,234.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		18,980,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		891,631,497.50
2105	Нормативт зардал		12,476,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		12,476,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		842,116,085.34
210601	Багаж, техник, хэрэгсэл		331,107,077.34
210602	Тавилга		65,956,370.00
210604	Урсгал засвар		445,052,638.00
2107	Томилолт, зочны зардал		160,000,000.00
210701	Гадаад албан томилолт		54,000,000.00
210702	Дотоод албан томилолт		95,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		11,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		850,233,191.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		710,233,191.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		140,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		11,224,950,391.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,224,950,391.45
210902	Гадаад валютын гарз		1,678,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,815,430,683.99
2132	Бусад урсгал шилжүүлэг		60,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		60,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,755,430,683.99
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		1,755,430,683.99
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		399,256,650.00
2200	Дотоод эх үүсвэрээр		399,256,650.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		399,256,650.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		16,955,723,103.28

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		16,955,723,103.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		14,990,253,682.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,965,469,420.80

АУДИТЫН ТАЙЛАН

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулах, хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитор Г.Ганбилэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2024 оны 4 дүгээр сарын 03-ний өдрийн ХЭГ/920 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 111,937.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,679.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлж, төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод өнгө бүхий улсын дугаараар сольж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан ч зарим харьяа байгууллага, хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 191.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэл

- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, видео контент хийсэн; /Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 19.2 сая төгрөг, Удирдлагын академ 4.6 сая төгрөг, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар 22.0 сая төгрөг, Боомтын сэрээлтийн Үндэсний хорооны даргын ажлын алба 20.8 сая төгрөг/
- Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын алба 125.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын материалын нөөц үүсгэсэн;

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
СНАГ-2025/11/НА-СТА-ТЕЗ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой нийт 3,920.7 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1,224.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 1 байгууллага шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Аудитын илрүүлэлт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 2,696.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал: Удирдлагын академи шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, өмнөх оны албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан;

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 1,224.0 сая төгрөгийг 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл болон бусад нийцлийн асуудал нь Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хуулийн зарим заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 234.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 226.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 8.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 13.Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	2	226.0	2	226.0	100.0
2	Зөвлөмж	2	8.0	2	8.0	100.0
	Нийт дүн	18	234.0	30	6,729.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд ТЗҮЭГ нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд Үндэсний их баяр наадмын үйлчилгээ, Тамгын газруудын цайны үйлчилгээ, кофе брейк зэрэг үйлчилгээ үзүүлж 1,766.7 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж, нэмэлт санхүүжилтийн дансандаа төвлөрүүлж, төрийн ордны албан өрөө болон нийтийн эзэмшлийн засвар үйлчилгээний зардалд зарцуулсан.

Мөн Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 224 дугаар тушаалаар давсан орлогоос 198.7 сая төгрөг зарцуулах эрх олгосны дагуу нэмэлт дансандаа төвлөрүүлж, зарцуулсан. Давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэхдээ орлого бууруулах бичилт хийснээр төсвийн гүйцэтгэлийн тайланд үйл ажиллагааны орлого бодит гүйцэтгэлээр биш зарцуулах эрх олгосон давсан орлогыг хассан дүнгээр буурч тайлагнагдаж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд үйл ажиллагааны орлогыг бодит гүйцэтгэлээр тайлагнахгүй байгаагаас дараа жилийн үйл ажиллагааны орлогыг хэт багаар төлөвлөж, жил бүр давсан орлого хэлбэрээр нь нэмэлт дансанд орлого төвлөрүүлж үр ашиггүй зарцуулах эрсэлтэй байгаа тул дараагийн аудитаар тус байгууллагуудын орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,170.6 сая төгрөгийн 11 алдаа¹ илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 1,526.2 сая төгрөгийн 44 зөрчил² илэрснээс, 35.7 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 960.4 сая төгрөгийн 21 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 228.0 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 302.1 сая төгрөгийн 14 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,526.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 152.9 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчил

ТЭЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 15 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 11 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бөгөөд 3 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар 4 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжээс тавих хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүү болон нийцлийн асуудлаар нийт 5,446.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 35.7 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 2,184.3 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага, 302.0 сая төгрөгийн зөрчилд 17 зөвлөмж өгч, 2,924.7 сая төгрөгийн зөрчилд 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ... 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, гүйцэтгэлийг хангаж ажиллах, албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Илрүүлэлт:

1.1 Тайлант онд ЗГХЭГ-ын орон тоо бүтцэд ордоггүй, бусад ерөнхийлөн захирагчийн

¹Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бүрэлдэхүүнд хамаарах шинээр 1 ажлын алба, 5 үндэсний хороог нэмж байгуулсан, 2 үндэсний хорооны орон тоог 14-өөр нэмэгдүүлснээс шалтгаалан, гүйцэтгэлээр өмнөх оноос орон тоо 83-аар, үйл ажиллагааны зардал 9,794.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Шинээр байгуулсан ажлын алба, үндэсний хороо:

- Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан шадар сайдын ажлын алба; /орон тоо төлөвлөгөөгөөр-15, гүйцэтгэлээр-13/
- Хяналт үнэлгээний үндэсний хороо; /орон тоо төлөвлөгөөгөөр-15, гүйцэтгэлээр-15/
- Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах үндэсний хороо; /орон тоо төлөвлөгөөгөөр-15, гүйцэтгэлээр-15/
- Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо; /орон тоо төлөвлөгөөгөөр-15, гүйцэтгэлээр-5/
- Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах үндэсний хороо; /орон тоо төлөвлөгөөгөөр-15, гүйцэтгэлээр-8/
- Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хороог /орон тоо төлөвлөгөөгөөр-15, гүйцэтгэлээр-13/ шинээр байгуулсантай холбогдуулан, гүйцэтгэлээр орон тоо 69-ээр, үйл ажиллагааны зардал 8,104.4 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Орон тоо нэмэгдүүлсэн үндэсний хороо:
- Боомтын сэргэлтийн үндэсний хорооны орон тоог 8, үйл ажиллагааны зардал 1,420.3 сая төгрөгөөр нэмэгдсэн; / орон тоо өмнөх оны гүйцэтгэлээр -5, тайлант оны гүйцэтгэлээр-13/
- Нийслэл Улаанбаатар хотын авто зам, түгжрэлийн бууруулах үндэсний хороог өөрчлөн 20 минутын хот үндэсний хороо байгуулснаар орон тоог 6, үйл ажиллагааны зардал 269.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн / орон тоо өмнөх оны гүйцэтгэлээр -6, тайлант оны гүйцэтгэлээр -12/ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

... Төрийн албыг цомхон, чадвартай боловсон хүчинтэй, бүтэц орон тоог бүрдүүлэхэд анхаарч, төсвийн ерөнхийлөн захирагч нарын ажлын алба, үндэсний хороодын орон тоо, бүтэц, ажлын байр, чиг үүргийн судалгааг гаргаж, давхардсан орон тоог хасаж, нэгтгэх, татан буулгах арга хэмжээг авах талаар санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2. Илрүүлэлт:

2.1 Бусад ТЕЗ-ын бүрэлдэхүүнд хамаарах, чиг үүрэг бүхий Хяналт үнэлгээний үндэсний хороо, Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах үндэсний хороо, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах үндэсний хороо, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хороо, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, 20 минутын хот үндэсний хороо гэсэн 7 хороог ЗГХЭГ-ын даргад харьяалуулан төсвийг баталж, тайлагнаж байгаа нь ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай удирдах, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцах чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 34² дугаар зүйлийн Сайдын ажлын алба 1-т "Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19, 20, 21 дэх заалтад заасан сайд нь тус тус ажлын албатай байна", 2-т "Сайдын ажлын алба нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Үндэсний хорооны ажлын албаны үүргийг хэрэгжүүлнэ", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 14.1.6-д "Шадар сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн", 14.1.8-д "боомтын сэргэлтийн асуудал эрхэлсэн

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Монгол Улсын сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн", 14.1.9-д "20-д минутын хотын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн", 14.1.10-д "хяналт, үнэлгээний асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн", Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 24-ны өдрийн Үндэсний хороо байгуулах тухай 09 дүгээр тогтоолын 1-д"...."Алсын хараа 2050" салбар дундын уялдааг хангах Үндэсний хороог байгуулж, Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт...", Засгийн газрын 2024 оны 6 дүгээр сарын 25-ны өдрийн Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 95 дугаар тогтоолын 1-т "Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолд энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүн" гэсэн 41 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралтаар баталсан "Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны бүрэлдэхүүн" гэсэн 42 дугаар хавсралт, 3 дугаар хавсралтаар баталсан "Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны бүрэлдэхүүн" гэсэн 43 дугаар хавсралт тус тус нэмсүгэй" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан тогтоолд зааснаар дээрх 7 хорооны төсвийг хамаарал бүхий ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад оруулан батлуулж, төсвийн гүйцэтгэл, санхүү, бүртгэл тайлагналд тавих хяналтыг шилжүүлэх саналыг Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны дээд байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

3.Илрүүлэлт:

3.1 Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор шинээр байгуулагдсан Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах үндэсний хороо, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагаанд шаардагдах нийт 4,825.5 сая төгрөгийн төсвийг Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас гүйцэтгэлээр нь тооцож олгохоор баталсны дагуу төсвийг ЗГХЭГ нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, гүйцэтгэлээр 1,448.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын нөөц сангийн 2021 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2 дугаар зүйлийн 2.2-т "ТЭЗ нь нөөц сангаас хөрөнгө зарцуулах тухай Засгийн газрын шийдвэрийн төслийг дор дурдсан шаардлагад нийцүүлэн боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зохих журмын дагуу хүргүүлж саналыг авч, тусгасан байна", 2.2.1-т "шийдвэрийн төсөл нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5-д заасан зориулалттай бүрэн нийцсэн болохыг танилцуулгад тодорхой тусгасан байх", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна", Төсвийн тухай хуулийн 28-1.2-т "Энэ хуулийн 28-1.1.1-т заасан хэлэлцүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 8 дугаар сард, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд дараах журмаар зохион байгуулна" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын нөөц сангаас Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах үндэсний хороо, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны төсвийг баталж зарцуулсан зөрчлийг арилгах талаар Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны дээд байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

5.3 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1	Засгийн газрын авто бааз	6	858.4					6	858.4				
2	Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар	1	14.6					1	14.6				
3	Удирдлагын академи	4	1,297.6	2	480.2			4	1,297.6				
Дүн		11	2,170.6	2	480.2			11	2,170.6	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	4	75.5			2	58.2	2	17.3				
2	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын ажлын алба	3	150.2	1	4.0	2	146.2						
3	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын ажлын алба	2	71.2			2	71.2						
4	Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан Монгол Улсын Шадар сайдын ажлын алба	3	24.4			1	14.4	2	10.0				
5	Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын ажлын алба	2	137.7			2	137.7						
6	Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар	1	55.8			1	55.8						
7	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар	2	5.7					2	5.7				
8	Засгийн газрын авто бааз	13	49.8	4	17.6	5	32.2	4					
9	Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын алба	1	125.1					1	25.1				
10	Удирдлагын академи	13	830.8	3	14.1	6	444.7	3	144.0	1.0	228.0		
Дүн		44	1,526.2	8	35.7	21	960.4	14	302.1	1	228.0	0	0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Засгийн газрын авто бааз	3	0					3	-				
2	Удирдлагын академи	2	3,920.7			1	1,224.0			1	2,696.7		
Дүн		5	3,920.7	-	-	1	1,224.0	3	-	1	2,696.7	-	-

